



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2019 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 58

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.6, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ Нь:

1. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 373,286 /турван зуун далан гурван мянга хоёр зуун наян зургаа/ төгрөгийн балансын үнэтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн Делл маркын зөвөрийн компьютерийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.
2. Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор акталж устган данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.СУХБААТАР

480219139